

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ
2024 ОНЫ ХАВРЫН ЭЭЛЖИТ ЧУУЛГАН



УЛСЫН ИХ ХУРЛЫН
ТАМГЫН ГАЗАР

2024 ОНЫ 04 ДҮГЭЭР САРЫН 30-НЫ ӨДӨР, МЯГМАР ГАРАГ

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ
УХААН, СПОРТЫН БАЙНГЫН
ХОРОО

ХУРАЛДААН ЗОХИОН БАЙГУУЛАХ ХЭЛТЭС

Та хуралдааны тэмдэглэлийн цахим хувьтай дээрх
QR кодыг уншуулан танилцах боломжтой.

**БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН, СПОРТЫН
БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН
АГУУЛГА**

2024 оны 04 дугаар сарын 30-ны өдөр, Мягмар гараг

<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	1
<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	2 - 11
<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	11 - 22
<i>1. Шинжлэх ухаан, технологийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2024.04.18-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/</i>	12 - 21
<i>2. Байнгын хорооны тогтоолын төсөл /Биеийн тамир, спортын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсэг байгуулах тухай/</i>	21 -22

**Монгол Улсын Их Хурлын 2024 оны хаврын ээлжит чуулганы
Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хорооны
04 дүгээр сарын 30-ны өдөр /Мягмар гараг/-ийн
хуралдааны товч тэмдэглэл**

Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхцэцэг ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 16 гишүүнээс 10 гишүүн хүрэлцэн ирж, 62.5 хувийн ирцтэйгээр хуралдаан 15 цаг 32 минутад Төрийн ордны “Үндсэн хууль” танхимд эхлэв.

*Томилолттой: А.Адъяасүрэн, Г.Дамдинням, Ч.Ундрам;
Чөлөөтэй: Б.Баярсайхан, Ё.Баатарбилэг;
Тасалсан: С.Чинзориг.*

Нэг.Шинжлэх ухаан, технологийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2024.04.18-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Боловсрол, шинжлэх ухааны сайд Л.Энх-Амгалан, Боловсрол, шинжлэх ухааны дэд сайд Г.Ганбаяр, Боловсрол, шинжлэх ухааны яамны Төрийн нарийн бичгийн дарга Х.Батжаргал, Шинжлэх ухааны академийн Ерөнхийлөгч Д.Рэгдэл, Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн ректор Т.Намнан, Боловсрол, шинжлэх ухааны яамны Шинжлэх ухаан, технологийн бодлого, инновацын хөгжүүлэлт, хэрэгжилтийг зохицуулах газрын ахлах шинжээч Ц.Намчинсүрэн, Шинжлэх ухаан, технологийн Үндэсний зөвлөлийн нарийн бичгийн дарга С.Мөнхбат, Монгол Улсын Их Сургуулийн Нано шинжлэх ухаан, нанотехнологийн төвийн захирал Ч.Ганзориг, Боловсрол, шинжлэх ухааны яамны Шинжлэх ухааны эрх зүйн асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн Б.Энхцэцэг нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Д.Нарантуяа, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Г.Агар-Эрдэнэ, мөн хэлтсийн Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Л.Лхагвасүрэн, референт Н.Монголмаа, Инновац, цахим бодлогын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Бат-Эрдэнэ нар байлцав.

Хуулийн төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх ажлын хэсгийн санал, дүгнэлтийг ажлын хэсгийн ахлагч, Улсын Их Хурлын гишүүн Б.Баттөмөр танилцуулав.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-т заасны дагуу Шинжлэх ухаан, технологийн тухай /Шинэчилсэн найруулга/ хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэв.

Нэг.ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН ТУХАЙ
/Шинэчилсэн найруулга/ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ТАЛААР
АЖЛЫН ХЭСГЭЭС ГАРГАСАН ЗАРЧМЫН ЗӨРҮҮТЭЙ
САНАЛЫН ТОМЬЁОЛОЛ

-Төслийн 1, 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

-Төслийн 1, 2 дугаар зүйлийг тус бүрээр хэлэлцэж дуусав.

Ц.Мөнхцэцэг: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн 3.1.3 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“3.1.3.“шинжлэх ухаан, технологийн үйл ажиллагаа” гэж хүрээлэн буй орчин, эдийн засаг, нийгмийн болон бусад асуудлыг шийдвэрлэхэд чиглэсэн судалгаа хөгжүүлэлтийн ажил гүйцэтгэх, шинжлэх ухаан, технологийн боловсрол олгох, шинжлэх ухаан, технологийн үйлчилгээ үзүүлэх цогц арга хэмжээг;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 2
Бүгд: 10
80.0 хувийн саналаар санал дэмжигдлээ.

2.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 3.1.6 дахь заалт нэмж, мөн зүйлийн 3.1.15 дахь заалтын “3.1.12-т” гэснийг “3.1.13-т” гэж өөрчлөх.

“3.1.6.“грант” гэж иргэн, хуулийн этгээд, гадаадын болон олон улсын байгууллага урьдчилсан нөхцөл, болзол тавьсны үндсэн дээр тодорхой судалгаа, шинжилгээний ажил явуулах зориулалтаар шинжлэх ухааны үйл ажиллагаанд оролцогчдод буцалтгүй олгож байгаа мөнгөн болон бусад хөрөнгийг;” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 3
Бүгд: 10
70.0 хувийн саналаар санал дэмжигдлээ.

-Төслийн 4, 5, 6, 7 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

-Төслийн 4, 5, 6, 7 дугаар зүйлийг тус бүрээр хэлэлцэж дуусав.

Ц.Мөнхцэцэг: 3.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 8 дугаар зүйлийн гарчгийн, мөн зүйлийн 8.1 дэх хэсгийн “үндэсний” гэснийг “удирдлагын” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 2
Бүгд: 10
80.0 хувийн саналаар санал дэмжигдлээ.

-Төслийн 9 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

-Төслийн 9 дүгээр зүйлийг хэлэлцэж дуусав.

Ц.Мөнхцэцэг: 4.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 10 дугаар зүйлийн 10.1.6.ж дэд заалтыг хасаж, төслийн 11 дүгээр зүйлийн 11.3 дахь хэсгийн “20 хүртэл” гэснийг “19” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 2
Бүгд: 10
80.0 хувийн саналаар санал дэмжигдлээ.

-Төслийн 12 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

-Төслийн 12 дугаар зүйлийг хэлэлцэж дуусав.

Ц.Мөнхцэцэг: 5.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 13 дугаар зүйлийн 13.3, 14 дүгээр зүйлийн 14.3 дахь заалтын “...үлгэрчилсэн дүрмийг Ерөнхий сайдын захирамжаар батална” гэснийг “...үлгэрчилсэн дүрмийг Засгийн газрын тогтоолоор батална” гэж тус тус өөрчилж, мөн 14 дүгээр зүйлийн 14.3 дахь заалтын “үлгэрчилсэн” гэсний өмнө “ажиллах” гэснийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 2
Бүгд: 10
80.0 хувийн саналаар санал дэмжигдлээ.

6.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 15 дугаар зүйлийн 15.1.6 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“15.1.6.үндэсний судалгаа, хөгжүүлэлтийн төсөл, суурь болон хэрэглээний судалгаа, технологийн туршилт, зүгшрүүлэлтийн ажлын чиглэл, санхүүжилтийг батлах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 3
Бүгд: 10

70.0 хувийн саналаар санал дэмжигдлээ.

7.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 16 дугаар зүйлийн 16.2.5 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“16.2.5.шинжлэх ухаан, технологийн урьдчилсан таамаглалд шаардлагатай баримт материалыг энэ хуулийн 3.1.14-өөс 3.1.18-д заасан болон холбогдох төрийн байгууллагаас гаргуулан авах” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 2
Бүгд: 10

80.0 хувийн саналаар санал дэмжигдлээ.

-Төслийн 17, 18, 19, 20, 21 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

-Төслийн 17, 18, 19, 20, 21 дүгээр зүйлийг тус бүрээр хэлэлцэж дуусав.

Ц.Мөнхцэцэг: 8.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 22 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 22.2 дахь хэсэг нэмэх:

“22.2.Засгийн газар хувийн хэвшлийн судалгаа хөгжүүлэлтийн ажлын хөрөнгө оруулалтад татварын хөнгөлөлт, чөлөөлөлт үзүүлэх бөгөөд уг асуудлыг татварын хууль тогтоомжид заасны дагуу шийдвэрлэнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 3
Бүгд: 10

70.0 хувийн саналаар санал дэмжигдлээ.

9.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 23 дугаар зүйлийн гарчгийг “Эрдэм шинжилгээний байгууллагын судалгааны үндсэн чиглэлийг дэмжих” гэж өөрчилж, мөн зүйлийн 23.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“23.1.Засгийн газар төрийн өмчит эрдэм шинжилгээний байгууллагын судалгааны үндсэн чиглэлд санхүүжилтийн дэмжлэг олгоно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 2
Бүгд: 10

80.0 хувийн саналаар санал дэмжигдлээ.

10.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 24 дүгээр зүйлийн 24.1, 24.3 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“24.1.Хууль тогтоомж, олон улсын гэрээнд өөрөөр заагаагүй бол олон улсын байгууллага, гадаад улсын иргэн, хуулийн этгээд Монгол Улсын нутаг дэвсгэрт хамтарсан эрдэм шинжилгээний байгууллага байгуулах, шинжлэх ухаан, технологийн хамтарсан төсөл хэрэгжүүлэх эрхтэй.

24.3.Монгол Улсын харьяат, эрдэмтэн судлаач, эрдэм шинжилгээний байгууллага нь гадаад улс, олон улсын байгууллага, шинжлэх ухааны нийгэмлэг, холбоонд гишүүнээр элсэх эрхтэй.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 2
Бүгд: 10
80.0 хувийн саналаар санал дэмжигдлээ.

-Төслийн 25, 26 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

-Төслийн 25, 26 дугаар зүйлийг тус бүрээр хэлэлцэж дуусав.

Ц.Мөнхцэцэг: 11.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 27 дугаар зүйлийн 27.2 дахь хэсгийн “авьяаслаг судлаачдыг” гэснийг “авьяас, ур чадвартай судлаачийг” гэж, мөн зүйлийн 27.3 дахь хэсгийн “авьяаслаг эрдэмтэн, судлаачийг” гэснийг “авьяас, ур чадвартай, мэргэшсэн эрдэмтэн, судлаачийг” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 2
Бүгд: 10
80.0 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Ц.Мөнхцэцэг: 12.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 28 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 28.7 дахь хэсэг нэмэх:

“28.7.Эрдэм шинжилгээний байгууллагын үндсэн чиглэлээр ахисан түвшний сургалтад хамрагдаж байгаа эрдэм шинжилгээний ажилтанд сургалтын төлбөрийн 100 хүртэл хувийн дэмжлэгийг тухайн эрдэм шинжилгээний байгууллагаас үзүүлж болно.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Дээрх саналтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Б.Баттөмөр санал хэлэв.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 2
Бүгд: 10
80.0 хувийн саналаар санал дэмжигдлээ.

-Төслийн 29, 30 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

-Төслийн 29, 30 дугаар зүйлийг тус бүрээр хэлэлцэж дуусав.

Ц.Мөнхцэцэг: 13.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 31 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 31.4 дэх хэсэг нэмэх:

“31.4.Засгийн газар, төрийн болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд шинжлэх ухаан, технологийн төсөл, үндэсний судалгаа хөгжүүлэлтийн төсөл, суурь судалгаа, хэрэглээний судалгаа, технологийн туршилт зүгшрүүлэлтийн ажлыг төрийн өмчийн эрдэм шинжилгээний байгууллагаар гүйцэтгүүлж санхүүжүүлэхэд Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийг дагаж мөрдөхгүй.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн:	7
Татгалзсан:	3
Бүгд:	10

70.0 хувийн саналаар санал дэмжигдлээ.

-Төслийн 32, 33, 34 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

-Төслийн 32, 33, 34 дүгээр зүйлийг тус бүрээр хэлэлцэж дуусав.

14.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 35 дугаар зүйлийн 35.1.1 дэх заалтын “судлаачдын хамтлагт” гэснийг “судлаачид” гэж, 36 дугаар зүйлийн “Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн дагуу шийдвэрлэнэ.” гэснийг “холбогдох хууль тогтоомжийн дагуу шүүхээр шийдвэрлүүлнэ.” гэж тус тус өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн:	8
Татгалзсан:	2
Бүгд:	10

80.0 хувийн саналаар санал дэмжигдлээ.

15.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 37 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“37 дугаар зүйл.Хууль зөрчигчид хүлээлгэх хариуцлага

37.1.Энэ хуулийг зөрчсөн үйлдэл нь гэмт хэргийн шинжгүй бол Төрийн албаны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

37.2.Энэ хуулийг зөрчсөн иргэн, хуулийн этгээдэд Эрүүгийн хууль, эсхүл Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 3
Бүгд: 10
70.0 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.10-т заасны дагуу Шинжлэх ухаан, технологийн тухай /Шинэчилсэн найруулга/ хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн бусад хуулийн төслүүдийг зүйл бүрээр хэлэлцэв.

**Хоёр.ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН ТУХАЙ
/Шинэчилсэн найруулга/ ХУУЛИЙН ТӨСӨЛТЭЙ ХАМТ ӨРГӨН МЭДҮҮЛСЭН
БУСАД ХУУЛИЙН ТӨСЛҮҮДИЙН ТАЛААР АЖЛЫН ХЭСГЭЭС ГАРГАСАН
ЗАРЧМЫН ЗӨРҮҮТЭЙ САНАЛЫН ТОМЬЁОЛОЛ**

**1.ШИНЖЛЭХ УХААН, ТЕХНОЛОГИЙН ТУХАЙ ХУУЛЬ
ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ
ХУУЛИЙН ТӨСӨЛ**

-Төслийн 1, 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

-Төслийн 1, 2 дугаар зүйлийг тус бүрээр хэлэлцэж дуусав.

**2.БОЛОВСРОЛЫН ЕРӨНХИЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ
ХУУЛИЙН ТӨСӨЛ**

-Төслийн 1, 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

-Төслийн 1, 2 дугаар зүйлийг тус бүрээр хэлэлцэж дуусав.

**3.ДЭЭД БОЛОВСРОЛЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ
ХУУЛИЙН ТӨСӨЛ**

Ц.Мөнхцэцэг: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“1 дүгээр зүйл.Дээд боловсролын тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1 дэх хэсгийн “Шинжлэх ухаан” гэснийг “Үндэсний Шинжлэх ухаан, технологийн” гэж өөрчилсүгэй.” гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 2
Бүгд: 10
80.0 хувийн саналаар санал дэмжигдлээ.

-Төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

-Төслийн 2 дугаар зүйлийг хэлэлцэж дуусав.

4.ИННОВАЦЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛ

-Төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

-Төслийн 1 дүгээр зүйлийг хэлэлцэж дуусав.

Ц.Мөнхцэцэг: 1.Ажлын хэсгийн гаргасан, Төслийн 2 дугаар зүйлийг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 3
Бүгд: 10
70.0 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Ц.Мөнхцэцэг: Ажлын хэсгийн гаргасан, Төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томъёолол дэмжигдсэнтэй холбогдуулан төслийн бүтэц, нэр, томъёо, хэл найруулга, дэс дараалал, зүйл заалтын дугаар, эшлэлийг нийцүүлэн өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 3
Бүгд: 10
70.0 хувийн саналаар санал дэмжигдлээ.

5.ЗАСГИЙН ГАЗРЫН ТУСГАЙ САНГИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛ

-Төслийн 1, 2, 3, 4 дүгээр зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

-Төслийн 1, 2, 3, 4 дүгээр зүйлийг тус бүрээр хэлэлцэж дуусав.

6.СТАНДАРТЧИЛАЛ, ТЕХНИКИЙН ЗОХИЦУУЛАЛТ, ТОХИРЛЫН ҮНЭЛГЭЭНИЙ ИТГЭМЖЛЭЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛ

-Төслийн 1, 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

-Төслийн 1, 2 дугаар зүйлийг тус бүрээр хэлэлцэж дуусав.

7.СТАТИСТИКИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛ

-Төслийн 1, 2, 3 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

-Төслийн 1, 2, 3 дугаар зүйлийг тус бүрээр хэлэлцэж дуусав.

8.ХӨГЖЛИЙН БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТ, ТҮҮНИЙ УДИРДЛАГЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛ

-Төслийн 1, 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

-Төслийн 1, 2 дугаар зүйлийг тус бүрээр хэлэлцэж дуусав.

9.ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН УЛСЫН БҮРТГЭЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛ

-Төслийн 1, 2 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

-Төслийн 1, 2 дугаар зүйлийг тус бүрээр хэлэлцэж дуусав.

10.ШИНЖЛЭХ УХААНЫ АКАДЕМИЙН ЭРХ ЗҮЙН БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛ

-Төслийн 1, 2, 3 дугаар зүйлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

-Төслийн 1, 2, 3 дугаар зүйлийг тус бүрээр хэлэлцэж дуусав.

11.“ТОГТООЛЫН ХАВСРАЛТАД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ” МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛЫН ТӨСӨЛ

-Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

-Тогтоолын төслийг хэлэлцэж дуусав.

Шинжлэх ухаан, технологийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Б.Баттөмөр Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 16 цаг 03 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.Байнгын хорооны тогтоолын төсөл /Биеийн тамир, спортын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсэг байгуулах тухай/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Л.Лхагвасүрэн, референт Н.Монголмаа нар байлцав.

Байнгын хорооны тогтоолын төслийн талаарх танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхцэцэг танилцуулав.

Ц.Мөнхцэцэг: “Ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг батлах санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 3
Бүгд: 10
70.0 хувийн саналаар Байнгын хорооны тогтоол батлагдлаа.

Уг асуудлыг 16 цаг 05 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 2 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 34 минут үргэлжилж, 16 гишүүнээс 10 гишүүн хүрэлцэн ирж, 62.5 хувийн ирцтэйгээр 16 цаг 06 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:

БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААН,
СПОРТЫН БАЙНГЫН ХОРООНЫ
ДАРГА

Б.БАЯРСАЙХАН

Тэмдэглэл хөтөлсөн:

ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ХӨТЛӨХ АЛБАНЫ
ШИНЖЭЭЧ

Ц.АЛТАН-ОД

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2024 оны 04 дүгээр сарын 30-ны өдөр,
Мягмар гараг
Төрийн ордны “Үндсэн хууль” танхим
15 цаг 32 минут

БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Ц.Мөнхцэцэг: Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хорооноос ирвэл зохих 16 гишүүнээс 10 гишүүн ирсэн байна.

Ингээд Та бүхэнд хуралдааны ирцийг танилцуулъя.

Тилеуханы Аубакир гишүүн, 2 дугаар тойрог ирсэн байна. Энхбаярын Батшугар гишүүн, 28 дугаар тойрог ирсэн байна. Хассуурийн Ганхуяг гишүүн, Баянгол дүүрэг, 26 дугаар тойрог ирсэн байна. Гомпилдоогийн Мөнхцэцэг, 6 дугаар тойрог ирсэн байна. Цэрэнжамцын Мөнхцэцэг, 24

дүгээр тойрог ирсэн байна. Ням-Осорын Учрал, 28 дугаар тойрог ирсэн байна. Лувсанцэрэнгийн Энх-Амгалан, 17 дугаар тойрог ирсэн байна. Жигжидсүрэнгийн Чинбүрэн, 23 дугаар тойрог ирсэн байна. Бадарчийн Жаргалмаа, 27 дугаар тойрог ирсэн байна.

Ингээд Та бүхэнд хуралдааны хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

Нэг. Шинжлэх ухаан, технологийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцэнэ.

Хоёр дахь асуудал нь, “Ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг батална.

Хэлэлцэх асуудал дээр өөр саналтай гишүүд байна уу? Байхгүй байна. /алх цохив/

Хэлэлцэх асуудалдаа орёё.

Нэг.Шинжлэх ухаан, технологийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүд /Засгийн газар 2024.04.18-ны өдөр өргөн мэдүүлсэн, анхны хэлэлцүүлэг/

Шинжлэх ухаан, технологийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн анхны хэлэлцүүлгийг явуулъя.

Байнгын хорооны хуралдаанд оролцож байгаа ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг танилцуулъя.

Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд Х.Батжаргал Боловсрол, шинжлэх ухааны яамны Төрийн нарийн бичгийн дарга, Г.Ганбаяр Боловсрол шинжлэх ухааны дэд сайд, Д.Рэгдэл Шинжлэх ухааны академийн Ерөнхийлөгч, Т.Намнан Шинжлэх ухаан, технологийн их сургуулийн ректор, Ц.Намчинсүрэн Боловсрол, шинжлэх ухааны яамны Шинжлэх ухаан, технологийн бодлого,

инновацийн хөгжүүлэлт, хэрэгжилтийг зохицуулах газрын ахлах шинжээч, С.Мөнхбат Шинжлэх ухаан, технологийн Үндэсний зөвлөлийн нарийн бичгийн дарга, Ч.Ганзориг Монгол Улсын Их Сургуулийн Нано шинжлэх ухаан, нанотехнологийн төвийн захирал, Б.Энхцэцэг Боловсрол, шинжлэх ухааны яамны Шинжлэх ухааны эрх зүйн асуудал хариуцсан ахлах мэргэжилтэн.

Байнгын хорооны ажлын хэсгийн танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Баагаагийн Баттөмөр танилцуулна.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 39.10-д Байнгын хороо хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэнэ гэж заасны дагуу Шинжлэх ухаан, технологийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг зүйл бүрээр хэлэлцэнэ.

Ингээд Б.Баттөмөр гишүүн таныг ажлын хэсгийн танилцуулгыг хийхийг урьж байна.

Б.Баттөмөр: Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Шинжлэх ухаан, технологийн тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн ажлын хэсгийн хурлыг 2024 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн хуралдаанаар хэлэлцэж Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хорооны анхны хэлэлцүүлэгт бэлдүүлэхээр шилжүүлсэн.

Шинжлэх ухаан, технологийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийн ажлын хэсгийн ахлагчаас баталсан дэд ажлын

хэсгийн хурлыг 3 удаа, Улсын Их Хурлын даргын 2024 оны 04 сарын 19-ний 60 дугаар захирамжаар байгуулагдсан ажлын хэсгийн хурлыг 2 удаа хуралдуулж асуудлыг хэлэлцсэн болно.

Ажлын хэсгээс Шинжлэх ухаан, технологийн хуулийн төсөлд 15 зарчмын зөрүүтэй санал гарсныг хуралдаанд оролцсон гишүүдийн 100 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн Ж.Чинбүрэн Шинжлэх ухаан, технологийн тухай хуулийн 22 дугаар зүйлд Засгийн газар хувийн хэвшлийн судалгаа, хөгжүүлэлтийн ажлын хөрөнгө оруулалтад татварын хөнгөлөлт, чөлөөлөлт үзүүлэх тухай асуудлыг татварын хууль тогтоомжид зааснаар шийдвэрлэх тухай санал гаргасныг хуралдаанд оролцсон гишүүд санал нэгтэй дэмжлээ.

Мөн Шинжлэх ухаан, технологийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийн зарчмын зөрүүтэй 2 санал гарсны хуралдаанд оролцсон гишүүд мөн дэмжлээ.

Та бүхэнд Шинжлэх ухаан, технологийн хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналыг тараасан болно.

Байнгын хорооны эрхэм гишүүд ээ,

Шинжлэх ухаан, технологийн хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийн талаарх ажлын хэсгээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг хэлэлцэж шийдвэрлэж өгөхийг хүсье.

Анхаарал тавьсанд баярлалаа.

Ц.Мөнхцэцэг: Монгол Улсын Их Хурлын хуралдааны дэгийн тухай хуулийн 39.10-д заасны дагуу Байнгын хороо хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэнэ гэж заасны дагуу Шинжлэх ухаан, технологийн хуулийн төслийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэнэ.

Гишүүн хуулийн төслийн зүйлтэй холбогдуулан хууль санаачлагчаас асуулт асууж болно.

Ингээд төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асууж, зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүд байна уу? Алга байна. /алх цохив/

Төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асууж, зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүд байна уу? Байхгүй байна.

Төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асууж, зарчмын зөрүүтэй санал хэлэх гишүүн байна уу?

Энэ дээр ажлын хэсгийн нэг санал байгаа юм байна.

1.Төслийн 3 дугаар зүйлийн 3.1.3 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“3.1.3.“шинжлэх ухаан, технологийн үйл ажиллагаа” гэж хүрээлэн буй орчин, эдийн засаг, нийгмийн болон бусад асуудлыг шийдвэрлэхэд чиглэсэн судалгаа хөгжүүлэлтийн ажил гүйцэтгэх, шинжлэх ухаан, технологийн боловсрол олгох,

шинжлэх ухаан, технологийн үйлчилгээ үзүүлэх цогц арга хэмжээг;”

Санал гаргасан ажлын хэсэг. Санал хураалт. /алх цохив/

80.0 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Төслийн 3 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 3.1.6 дахь заалт нэмж, мөн зүйлийн 3.1.15 дахь заалтын “3.1.12-т” гэснийг “3.1.13-т” гэж өөрчлөх.

“3.1.6.“грант” гэж иргэн, хуулийн этгээд, гадаадын болон олон улсын байгууллага урьдчилсан нөхцөл, болзол тавьсны үндсэн дээр тодорхой судалгаа, шинжилгээний ажил явуулах зориулалтаар шинжлэх ухааны үйл ажиллагаанд оролцогчдод буцалтгүй олгож байгаа мөнгөн болон бусад хөрөнгийг;”

Санал гаргасан Ажлын хэсэг. Санал хураалт. /алх цохив/

70.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Төслийн 4 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асууж, зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүд байна уу? Байхгүй байна. /алх цохив/

Төслийн 5 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асууж, зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүн байна уу? Байхгүй байна. /алх цохив/

Төслийн 6 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асууж, зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүн байна уу? Байхгүй байна. /алх цохив/

Төслийн 7 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асууж, зарчмын

зөрүүтэй санал гаргах гишүүн байна уу?
Байхгүй байна. /алх цохив/

Төслийн 8 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асууж, зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүн байна уу?

8 дээр ажлын хэсгийн санал байна.

3.Төслийн 8 дугаар зүйлийн гарчгийн, мөн зүйлийн 8.1 дэх хэсгийн “үндэсний” гэснийг “удирдлагын” гэж өөрчлөх.

Санал гаргасан ажлын хэсэг.
Санал хураалт. /алх цохив/

80.0 хувийн саналаар санал дэмжигдлээ.

Төслийн 9 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асууж, зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүн байна уу?
Байхгүй байна. /алх цохив/

Төслийн 10 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асууж, зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүн байна уу?
Байхгүй байна. /алх цохив/

Төслийн 10 дугаар зүйл дээр ажлын хэсгийн санал байна.

4.Төслийн 10 дугаар зүйлийн 10.1.6.ж дэд заалтыг хасаж, төслийн 11 дүгээр зүйлийн 11.3 дахь хэсгийн “20 хүртэл” гэснийг “19” гэж өөрчлөх.

Ажлын хэсгийн санал. Санал хураалт. /алх цохив/

80.0 хувиар дэмжигдлээ.

Төслийн 12 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асууж, зарчмын

зөрүүтэй санал гаргах гишүүн байна уу?
Алга байна. /алх цохив/

Төслийн 13 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асууж, зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүн байна уу?

Ажлын хэсгийн санал байна.

5.Төслийн 13 дугаар зүйлийн 13.3, 14 дүгээр зүйлийн 14.3 дахь заалтын “...үлгэрчилсэн дүрмийг Ерөнхий сайдын захирамжаар батална” гэснийг “...үлгэрчилсэн дүрмийг Засгийн газрын тогтоолоор батална” гэж тус тус өөрчилж, мөн 14 дүгээр зүйлийн 14.3 дахь заалтын “үлгэрчилсэн” гэсний өмнө “ажиллах” гэснийг хасах.

Санал хураалт. /алх цохив/

80.0 хувиар дэмжигдлээ.

Төслийн 15 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асууж, зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүн байна уу?

Энэ дээр ажлын хэсгийн санал байна.

6.Төслийн 15 дугаар зүйлийн 15.1.6 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“15.1.6.үндэсний судалгаа, хөгжүүлэлтийн төсөл, суурь болон хэрэглээний судалгаа, технологийн туршилт, зүгшрүүлэлтийн ажлын чиглэл, санхүүжилтийг батлах.

Санал хураалт. /алх цохив/

70.0 хувиар дэмжигдлээ.

Төслийн 16 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асууж, зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүн байна уу?

Анэ дээр ажлын хэсгийн санал байна.

7.Төслийн 16 дугаар зүйлийн 16.2.5 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“16.2.5.шинжлэх ухаан, технологийн урьдчилсан таамаглалд шаардлагатай баримт материалыг энэ хуулийн 3.1.14-өөс 3.1.18-д заасан болон холбогдох төрийн байгууллагаас гаргуулан авах”

Ажлын хэсгийн саналаар санал хураалт. /алх цохив/

80.0 хувиар дэмжигдлээ.

Төслийн 17 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асууж, зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүн байна уу? Алга байна. /алх цохив/

Төслийн 18 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асууж, зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүн байна уу? Алга байна. /алх цохив/

Төслийн 19 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асууж, зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүн байна уу? Алга байна. /алх цохив/

Төслийн 20 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асууж, зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүн байна уу? Алга байна. /алх цохив/

Төслийн 21 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асууж, зарчмын

зөрүүтэй санал гаргах гишүүн байна уу? Алга байна. /алх цохив/

Төслийн 22 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асууж, зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүн байна уу?

22 дээр ажлын хэсгийн санал байна.

8.Төслийн 22 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 22.2 дахь хэсэг нэмэх:

“22.2.Засгийн газар хувийн хэвшлийн судалгаа хөгжүүлэлтийн ажлын хөрөнгө оруулалтад татварын хөнгөлөлт, чөлөөлөлт үзүүлэх бөгөөд уг асуудлыг татварын хууль тогтоомжид заасны дагуу шийдвэрлэнэ.”

Санал хураалт. /алх цохив/

70.0 хувиар дэмжсэн байна.

Төслийн 23 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асууж, зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүн байна уу?

23 дугаар зүйл дээр ажлын хэсгийн санал байгаа.

9.Төслийн 23 дугаар зүйлийн гарчгийг “Эрдэм шинжилгээний байгууллагын судалгааны үндсэн чиглэлийг дэмжих” гэж өөрчилж, мөн зүйлийн 23.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“23.1.Засгийн газар төрийн өмчит эрдэм шинжилгээний байгууллагын судалгааны үндсэн чиглэлд санхүүжилтийн дэмжлэг олгоно.”

Ажлын хэсгийн гаргасан саналаар санал хураалт. /алх цохив/

80 хувь нь дэмжсэн байна.

Төслийн 24 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асууж, зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүн байна уу?

24 дүгээр зүйл дээр ажлын хэсгийн санал байна.

10.Төслийн 24 дүгээр зүйлийн 24.1, 24.3 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“24.1.Хууль тогтоомж, олон улсын гэрээнд өөрөөр заагаагүй бол олон улсын байгууллага, гадаад улсын иргэн, хуулийн этгээд Монгол Улсын нутаг дэвсгэрт хамтарсан эрдэм шинжилгээний байгууллага байгуулах, шинжлэх ухаан, технологийн хамтарсан төсөл хэрэгжүүлэх эрхтэй.

24.3.Монгол Улсын харьяат, эрдэмтэн судлаач, эрдэм шинжилгээний байгууллага нь гадаад улс, олон улсын байгууллага, шинжлэх ухааны нийгэмлэг, холбоонд гишүүнээр элсэх эрхтэй.”

Ажлын хэсгийн гаргасан саналаар санал хураалт явуулъя. Санал хураалт. /алх цохив/

80.0 хувиар дэмжигдсэн байна.

Төслийн 25 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асууж, зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүн байна уу? Алга байна. /алх цохив/

Төслийн 26 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асууж, зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүн байна уу? Алга байна. /алх цохив/

Төслийн 27 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асууж, зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүн байна уу?

Төслийн 27 дугаар зүйл дээр ажлын хэсгийн санал байна.

11.Төслийн 27 дугаар зүйлийн 27.2 дахь хэсгийн “авьяаслаг судлаачдыг” гэснийг “авьяас, ур чадвартай судлаачийг” гэж, мөн зүйлийн 27.3 дахь хэсгийн “авьяаслаг эрдэмтэн, судлаачийг” гэснийг “авьяас, ур чадвартай, мэргэшсэн эрдэмтэн, судлаачийг” гэж тус тус өөрчлөх.

Санал хураалт. /алх цохив/

80.0 хувийн саналаар дэмжсэн байна.

Төслийн 28 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асууж, зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүн байна уу?

Ажлын хэсгийн ахлагч Б.Баттөмөр гишүүн.

Б.Баттөмөр: Энэ 28 дугаар зүйлийн 28.7 дахь хэсэг дээр нэмэхдээ “эрдэм шинжилгээний байгууллага нь үндсэн чиглэлээр ахисан түвшний сургалтад хамрагдаж байгаа эрдэм шинжилгээний ажилтанд сургалтын төлбөрийг 100 хүртэл хувийн дэмжлэгийг тухайн эрдэм шинжилгээний байгууллагаас үзүүлж болно” гэж ингэж томъёолсон юм.

“Дотоодын” гэсэн үгийг нь хасчихъя. Гийм. Хасаад уншчихъя. Тэгэхээр “үндсэн чиглэлээр ахисан түвшний” гэж байгаа юм. Та хасаад уншчихад болно.

Ц.Мөнхцэцэг: Төслийн 28.7-д ажлын хэсгийн гаргасан саналыг Та бүхэндээ уншиж өгье.

12.Төслийн 28 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 28.7 дахь хэсэг нэмэх:

“28.7.Эрдэм шинжилгээний байгууллагын үндсэн чиглэлээр ахисан түвшний сургалтад хамрагдаж байгаа эрдэм шинжилгээний ажилтанд сургалтын төлбөрийн 100 хүртэл хувийн дэмжлэгийг тухайн эрдэм шинжилгээний байгууллагаас үзүүлж болно.”

Ажлын хэсгийн гаргасан саналаар санал хураалт явуулья. Санал хураалт. /алх цохив/

80.0 хувиар дэмжсэн байна.

Төслийн 29 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асууж, үг хэлэх, зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүн байна уу? Алга байна. /алх цохив/

Төслийн 30 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асууж, зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүн байна уу? Алга байна. /алх цохив/

Төслийн 31 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асууж, зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүн байна уу?

Төслийн 31 дээр ажлын хэсгийн санал гарсан байгаа.

13.Төслийн 31 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 31.4 дэх хэсэг нэмэх:

“31.4.Засгийн газар, төрийн болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээд шинжлэх ухаан, технологийн төсөл, үндэсний судалгаа хөгжүүлэлтийн төсөл, суурь судалгаа, хэрэглээний

судалгаа, технологийн туршилт зүгшрүүлэлтийн ажлыг төрийн өмчийн эрдэм шинжилгээний байгууллагаар гүйцэтгүүлж санхүүжүүлэхэд Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийг дагаж мөрдөхгүй.”

Ажлын хэсгийн гаргасан саналаар санал хураалт явуулья. Санал хураалт. /алх цохив/

Ажлын хэсгийн гаргасан саналыг 70.0 хувиар дэмжсэн байна.

Төслийн 32 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асууж, зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүн байна уу? Алга байна. /алх цохив/

Төслийн 33 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асууж, зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүн байна уу? Алга байна. /алх цохив/

Төслийн 34 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асууж, зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүн байна уу? Алга байна. /алх цохив/

Төслийн 35 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асууж, зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүн байна уу?

35 дугаар зүйл дээр ажлын хэсгийн санал гарсан байна.

14.Төслийн 35 дугаар зүйлийн 35.1.1 дэх заалтын “судлаачдын хамтлагт” гэснийг “судлаачид” гэж, 36 дугаар зүйлийн “Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн дагуу шийдвэрлэнэ.” гэснийг “холбогдох хууль тогтоомжийн дагуу шүүхээр шийдвэрлүүлнэ.” гэж тус тус өөрчлөх.

Санал гаргасан ажлын хэсэг.
Санал хураалт. /алх цохив/

Ажлын хэсгийн гаргасан саналыг
80.0 хувиар дэмжсэн байна.

Төслийн 37 дугаар зүйлтэй
холбогдуулан асуулт асууж, зарчмын
зөрүүтэй санал гаргах гишүүн байна уу?

Төслийн 37 дугаар зүйл дээр
ажлын хэсгийн санал гарсан байна.

15.Төслийн 37 дугаар зүйлийг
доор дурдсанаар өөрчлөн найруулах:

“37 дугаар зүйл.Хууль
зөрчигчид хүлээлгэх хариуцлага

37.1.Энэ хуулийг зөрчсөн үйлдэл
нь гэмт хэргийн шинжгүй бол Төрийн
албаны тухай хууль, Хөдөлмөрийн тухай
хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

37.2.Энэ хуулийг зөрчсөн иргэн,
хуулийн этгээдэд Эрүүгийн хууль, эсхүл
Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага
хүлээлгэнэ.”

Ажлын хэсгийн гаргасан саналаар
санал хураалт явуулья. Санал хураалт.
/алх цохив/

Шинжлэх ухаан, технологийн
тухай хуулийн шинэчилсэн найруулгын
төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хуулийн
төслүүдийг хэлэлцэж эхэлье.

Шинжлэх ухаан, технологийн
тухай хууль хүчингүй болсонд тооцож
тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй
холбогдуулан асуулт асууж, зарчмын
зөрүүтэй саналтай гишүүн байна уу?
Байхгүй байна. /алх цохив/

Төслийн 2 дугаар зүйлтэй
холбогдуулан асуулт асууж, зарчмын
зөрүүтэй санал гаргах гишүүн байна уу?
Алга байна. /алх цохив/

Боловсролын ерөнхий хуульд
өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн
1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт
асууж, зарчмын зөрүүтэй санал гаргах
гишүүн байна уу? Алга байна. /алга
цохив/

Төслийн 2 дугаар зүйлтэй
холбогдуулан асуулт асууж, зарчмын
зөрүүтэй санал гаргах гишүүн байна уу?
Алга байна. /алга цохив/

Дээд боловсролын тухай хуульд
өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн
1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт
асууж, зарчмын зөрүүтэй санал гаргах
гишүүн байна уу?

Энэ дээр ажлын хэсгийн санал
байна.

Нэг.Дээд боловсролын тухай
хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн
төслийн талаар.

1.Төслийн 1 дүгээр зүйлийг доор
дурдсанаар өөрчлөн найруулах:

“1 дүгээр зүйл.Дээд боловсролын
тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1
дэх хэсгийн “Шинжлэх ухаан” гэснийг
“Үндэсний Шинжлэх ухаан,
технологийн” гэж өөрчилсүгэй.”

Ажлын хэсгийн гаргасан саналаар
санал хураалт явуулья. Санал хураалт.
/алх цохив/

Ажлын хэсгийн гаргасан саналыг
80.0 хувиар дэмжсэн байна.

Төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асууж, зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүн байна уу? Алга байна. /алга цохив/

Инновацын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асууж, зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүн байна уу?

Энэ дээр ажлын хэсгийн санал байгаа.

Хоёр.Инновацын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар.

1.Төслийн 2 дугаар зүйлийг хасах.

Ажлын хэсгийн гаргасан саналаар санал хураалт явуулъя. Санал хураалт. /алх цохив/

Ажлын хэсгийн гаргасан санал 70.0 хувиар дэмжигдсэн байна.

Төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томьёолол дэмжигдсэнтэй холбогдуулан төслийн бүтэц, нэр, томьёо, хэл найруулга, дэс дараалал, зүйл заалтын дугаар, эшлэлийг нийцүүлэн өөрчлөх.

Энэ Ажлын хэсгийн гаргасан санал байна. Санал хураалт явуулъя. /алх цохив/

Засгийн газрын тусгай сангийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асууж, зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүн байна уу? Алга байна. /алх цохив/

Төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асууж, зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүн байна уу? Алга байна. /алх цохив/

Төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асууж, зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүн байна уу? Алга байна. /алх цохив/

Төслийн 4 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асууж, зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүн байна уу? Алга байна. /алх цохив/

Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асууж, зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүн байна уу? Алга байна. /алх цохив/

Төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асууж, зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүн байна уу? Алга байна. /алх цохив/

Статистикийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асууж, зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүн байна уу? Алга байна. /алх цохив/

Төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асууж, зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүн байна уу? Алга байна. /алх цохив/

Төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асууж, зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүн байна уу? Алга байна. /алх цохив/

Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асууж, зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүн байна уу? Алга байна. /алх цохив/

Төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асууж, зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүн байна уу? Алга байна. /алх цохив/

Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асууж, зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүн байна уу? Байхгүй байна. /алх цохив/

Төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асууж, зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүн байна уу? Алга байна. /алх цохив/

Шинжлэх ухааны академийн эрх зүйн байдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлтэй холбогдуулан асуулт асууж, зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүн байна уу? Алга байна. /алх цохив/

Төслийн 2 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асууж, зарчмын

зөрүүтэй санал гаргах гишүүн байна уу? Алга байна. /алх цохив/

Төслийн 3 дугаар зүйлтэй холбогдуулан асуулт асууж, зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүн байна уу? Алга байна. /алх цохив/

“Тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төсөлтэй холбогдуулан асуулт асууж, зарчмын зөрүүтэй санал гаргах гишүүн байна уу? Алга байна. /алх цохив/

Шинжлэх ухаан, технологийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг зүйл бүрээр хэлэлцэж дууслаа. /алх цохив/

Байнгын хорооны санал, дүгнэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн, ажлын хэсгийн ахлагч Баагаагийн Баттөмөр танилцуулна.

Шинжлэх ухаан, технологийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Улсын Их Хурлын тогтоолын төслийн анхны хэлэлцүүлэг явуулж дууслаа. /алх цохив/

Хоёр.Байнгын хорооны тогтоолын төсөл

/Биеийн тамир, спортын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий
Ажлын хэсэг байгуулах тухай/

Дараагийн хэлэлцэх асуудалдаа орьё.

“Ажлын хэсэг байгуулах тухай” Байнгын хорооны тогтоолын төслийг хэлэлцье.

Байнгын хорооны хуралдаанаар батлагдах ажлын хэсэг бол Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.5 дахь хэсгийг үндэслэн Боловсрол, шинжлэх ухаан, спортын байнгын хорооноос ТОГТООХ нь.

Энэ бол Биеийн тамир, спортын хуулийн шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг Байнгын хорооны болон нэгдсэн хуралдаанд хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулах гэж байна.

Энэ ажлын хэсгийн бүрэлдэхүүнд орж ажиллахаар саналаа өгсөн. Нэмж ажлын хэсэгт ажиллах гишүүд байна уу? Биеийн тамир, спортын тухай ажлын хэсгийн бүрэлдэхүүн.

Биеийн тамир, спортын хуулийн төслийн хамт өргөн мэдүүлсэн хуулийн төсөл байгаа. Шинэчилсэн найруулга байгаа.

Ажлын хэсгийн ахлагчаар Улсын Их Хурлын гишүүн Ц.Мөнхцэцэг, гишүүдэд Улсын Их Хурлын гишүүн Б.Жаргалмаа, Улсын Их Хурлын гишүүн Б.Энх-Амгалан, Улсын Их Хурлын гишүүн Т.Аубакир, Улсын Их Хурлын гишүүн Г.Амартүвшин, Улсын Их Хурлын гишүүн А.Адьяасүрэн.

Мөн Х.Ганхуяг гишүүн нэмж орж ажиллах уу? Тэгэхээр Х.Ганхуяг гишүүн орчих. Ингээд нэрсийг танилцууллаа.

“Ажлын хэсэг байгуулах тухай” тогтоолын төслийг батлах санал хураалт явуулъя.

Ажлын дэд хэсгийг ажлын хэсгийн ахлагч өөрөө байгуулж ажиллахыг даалгая. Ингээд санал хураалт. /алх цохив/

Байнгын хорооны тогтоол гишүүдийн 70.0 хувиар батлагдлаа. Баярлалаа.

Өнөөдрийн хуралдааны хэлэлцэх асуудал ингээд өндөрлөснийг мэдэгдье.

Хуралдаан 2 цаг 07 минут үргэлжилж, 15 цаг 40 минутад өндөрлөв.

**БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ,
ХЯНАСАН: ШИНЖЭЭЧ**

Ц.АЛТАН-ОД